



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/621

Номгон

Сурлагын хоцрогдол нөхөх, арилгах арга
хэмжээний зардал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны 2022 оны 8/10 дугаар тогтоол, 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 16/45 дугаар тогтоолын 1 дэх заалт, аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах 6.1.3.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 2023 оны 16 дугаар хуралдаанаар “Ковидын дараах сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах арга хэмжээний төлөвлөгөө”-г (2021-2023 он) бүрэн хэрэгжсэн гэж үзсэн тул “Сурагчдын хичээл сурлагын хоцрогдлыг нөхөх арилгах төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг олгосугай.

2. Сурлагын хоцрогдлыг арилгах арга хэмжээний хүрээнд хоцрогдлын шалтгааныг боловсролын түвшингээр тогтоож, судлагдахуун тус бүрээр хэрэгжүүлэх зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж тайлагнахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Алтанцэцэг)-т үүрэг болгосугай.

3. Арга хэмжээний зардал 6.000.000 (Зургаан сая) төгрөгийн задаргааг хавсралтаар баталж, аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний “Сурагчдын хичээл сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах арга хэмжээний зардлаас судалгааны ажлын дүнгээр санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (В.Наранчимэг)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642311646

Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын
22 ны өдрийн 62 дүгээр захирамжийн хавсралт



СУРАГЧДЫН ХИЧЭЭЛ, СУРЛАГЫН ХОЦРОГДЛЫГ
НӨХӨХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ЗАРДАЛ

№	Үйл ажиллагаа	Тоо, ширхэг	Бүгд үнэ Мянган төгрөг
1	Бичиг хэргийн зардал: (бичгийн цаас, принтерийн хор)	50 боодол А-4 цаас, 5 хор	1795.0
2	Шалгалтын тест, даалгавар боловсруулах, засах, дүгнэлт гаргах /Судлагдахуун бүрээр /	15 судлагдахуун бүрээр	1500.0
3	Сумдад ажиллах томилолтын зардал	12 хүн 5 хоног	1440.0
3	Сумдад ажиллах Тээвэр, шатахууны зардал	Хангай, говийн чиглэлд 2500 км	1265.0
Нийт дүн (Зургаан сая төгрөг)			6000.0

_____оОо_____